



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2026/108/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mnp](http://www.audit.mnp)  
Эрдэнэбулган хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа  
Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalbaat@audit.gov.mn  
Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn  
Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг  
Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2025.02.25 № 124  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Б.ЭНХЗАЯА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй,
- Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээнд заасан эм эмнэлгийн хэрэгслийг худалдан аваагүй 4,917.6 мянган төгрөг,
- Эм боох бараа материалын үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ авч ажиллаагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй 41,685.3 мянган төгрөг,
- Эм, боох материалын бүртгэлд байгаа эм, эмийн хэрэгслийг НББ-ийн ОУ-ын стандартын дагуу ангилан бүртгээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 18.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.2, 16.5.3, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дахь заалтуудыг зөрчсөн иж бүрэн байх, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

#### Асуудлын онцлог хэсэг

Тус байгууллага нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 5268 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 222,067.4 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

#### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,570,587.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 29,979.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,505,907.5 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 94,659.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 13,400.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн газраас 4,531.2 мянган төгрөгийн, хөрөнгө дахин үнэлсний үр дүнгээр 18,564.6 мянган төгрөг нийт 36,495.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Эрүүл мэндийн газраас 24,162.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 87.7 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>298,340,554.94</u></b>	<b><u>456,984,720.80</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,830,366.31	94,659,657.55
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	1,830,366.31	94,659,657.55
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	1,830,366.31	94,659,657.55
31211	Төрийн сангийн харилцах	1,830,366.31	94,659,657.55
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	176,877,513.83	222,067,480.10
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	176,877,513.83	222,067,480.10
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	119,632,674.80	140,257,583.15
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	58,124,497.13	83,095,857.48
35130	Эм боох материал	58,124,497.13	83,095,857.48
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	61,508,177.67	57,161,725.67
35410	Бичиг хэргийн материал	468,600.00	222,100.00
35420	Аж ахуйн материал	48,877,077.67	48,345,825.67
35440	Түлш, шатах тослох материал	1,654,130.00	279,000.00
35450	Барилгын засварын материал	9,084,800.00	8,314,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>914,953,644.00</u></b>	<b><u>866,108,714.44</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	914,953,644.00	866,108,714.44
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	895,727,644.13	846,962,714.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	639,733,636.00	639,733,636.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(106,173,605.28)	(126,868,526.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141,460,060.00	141,460,060.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,201,249.00)	(49,228,622.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	231,658,230.21	235,344,430.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,738,948.05)	(76,818,251.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,004,836.40	104,353,024.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,592,026.54)	(21,526,735.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,952,000.00	3,952,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,454,889.61)	(3,517,899.58)
39217	Ном	79,600.00	79,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	19,225,999.87	19,145,999.83
39301	Програм хангамж	1,200,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(900,000.13)	(980,000.17)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,926,000.00	18,926,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,213,294,198.94</u></b>	<b><u>1,323,093,435.24</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,213,294,198.94</u></b>	<b><u>1,323,093,435.24</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,213,294,198.94	1,323,093,435.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,339,752.50	191,339,752.50
51101	Өмч: - төрийн	191,339,752.50	191,339,752.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	683,558,673.61	793,453,827.57
51210	Өмнөх үеийн үр дүн	683,558,673.61	683,654,591.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	109,799,236.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	338,395,772.83	338,299,855.17

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,213,294,198.94</u></b>	<b><u>1,323,093,435.24</u></b>
---	--	--------------------------------	--------------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,205,187,882.77</b>	<b>1,445,815,403.87</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,500,000.00</b>	<b>114,371,075.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,500,000.00	67,112,820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	67,112,820.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	67,112,820.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	47,258,255.27
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан ҮХ		23,095,960.07
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан БМ		24,162,295.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,201,687,882.77</b>	<b>1,331,444,328.60</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	32,825,700.00	29,979,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,825,700.00	29,979,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,168,862,182.77	1,301,464,428.60
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,168,862,182.77	1,301,464,428.60
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,200,563,951.36</b>	<b>1,336,016,167.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,200,563,951.36</b>	<b>1,336,016,167.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,177,056,779.55	1,265,243,348.88
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	748,334,251.68	828,151,820.04
210101	Үндсэн цалин	425,873,188.32	414,545,861.95
210102	Нэмэгдэл	239,784,412.08	322,456,429.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,284,000.00	16,602,000.00
210104	Урамшуулал	76,392,651.28	74,547,528.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,309,376.47	107,998,928.75
210201	Тэтгэврийн даатгал	73,663,499.99	73,136,672.77
210202	Тэтгэмжийн даатгал	6,161,519.12	8,610,907.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,080,709.56	4,591,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,080,709.56	4,541,617.96
210205	Эрүүл мэндийн даатгал	12,322,938.24	17,118,530.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,718,528.19	24,291,291.31
210301	Гэрэл, цахилгаан	4,614,708.19	7,514,576.31
210302	Түлш, халаалт	19,103,820.00	16,776,715.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	75,722,011.70	82,865,627.68
210401	Бичиг хэрэг	5,853,100.00	7,031,400.00
210402	Тээвэр, шатахуун	39,510,325.00	31,472,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,090,000.00	7,936,715.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,539,000.00	1,080,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,541,500.00	12,171,950.00
210408	Бараа материал акталсны зардал	12,188,086.70	23,173,462.68
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	142,150,001.83	113,431,057.47

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128,087,731.83	98,834,287.47
210502	Хоол, хүнс	14,062,270.00	14,596,770.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,038,100.00</b>	<b>6,061,000.00</b>
210604	Урсгал засвар	13,038,100.00	6,061,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,989,000.00</b>	<b>7,908,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,989,000.00	7,908,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,455,740.00</b>	<b>5,972,024.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,548,112.00	3,931,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	227,700.00	208,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,928.00	243,884.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	88,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>59,339,769.68</b>	<b>88,563,399.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,621,038.00	3,222,510.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,718,731.68	85,340,889.63
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,507,171.81</b>	<b>70,772,818.69</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,000,000.00</b>	<b>65,479,710.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,845,710.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	41,634,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,507,171.81</b>	<b>5,293,108.69</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,507,171.81	5,293,108.69
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,623,931.41</b>	<b>109,799,236.30</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,959,273.14</b>	<b>109,799,236.30</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,047,569,089.94</b>	<b>1,353,367,182.33</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,500,000.00</b>	<b>67,112,820.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,500,000.00</b>	<b>67,112,820.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,500,000.00</b>	<b>67,112,820.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	67,112,820.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,044,069,089.94</b>	<b>1,286,254,362.33</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>32,825,700.00</b>	<b>29,979,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,825,700.00	29,979,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,011,243,389.94</b>	<b>1,256,274,462.33</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,011,243,389.94	1,256,274,462.33
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,130,262,200.45</b>	<b>1,247,137,891.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,130,262,200.45</b>	<b>1,247,137,891.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,106,755,028.64</b>	<b>1,176,365,072.40</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	748,334,251.68	828,151,820.04
210101	Үндсэн цалин	425,873,188.32	414,545,861.95
210102	Нэмэгдэл	239,784,412.08	322,456,429.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,284,000.00	16,602,000.00
210104	Урамшуулал	76,392,651.28	74,547,528.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,309,376.47	107,998,928.75
210201	Тэтгэврийн даатгал	73,663,499.99	73,136,672.77
210202	Тэтгэмжийн даатгал	6,161,519.12	8,610,907.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,080,709.56	4,591,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,080,709.56	4,541,617.96
210205	Эрүүл мэндийн даатгал	12,322,938.24	17,118,530.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,318,528.19	23,691,291.31
210301	Гэрэл, цахилгаан	4,614,708.19	7,514,576.31
210302	Түлш, халаалт	19,703,820.00	16,176,715.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	63,427,375.00	61,629,735.00
210401	Бичиг хэрэг	5,525,300.00	6,784,900.00
210402	Тээвэр, шатахуун	39,085,075.00	30,119,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,090,000.00	7,486,715.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,141,700.00	1,230,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,585,300.00	16,008,350.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	121,433,719.30	125,927,263.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,651,619.30	107,980,563.30
210502	Хоол, хүнс	12,587,100.00	13,047,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,195,000.00	4,899,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,218,900.00	10,160,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	788,700.00
210604	Урсгал засвар	18,188,900.00	9,371,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,989,000.00	7,908,200.00
210702	Дотоод албан томилолт	6,989,000.00	7,908,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,955,740.00	6,422,024.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,048,112.00	4,381,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	227,700.00	208,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,928.00	243,884.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	88,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,768,138.00	4,475,610.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,768,138.00	4,475,610.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,507,171.81</b>	<b>70,772,818.69</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,000,000.00	65,479,710.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,845,710.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	41,634,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	6,507,171.81	5,293,108.69

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,507,171.81	5,293,108.69
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(82,693,110.51)</b>	<b>106,229,291.24</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>28,652,000.00</b>	<b>13,400,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,652,000.00</b>	<b>13,400,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	28,652,000.00	13,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,652,000.00	13,400,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(28,652,000.00)</b>	<b>(13,400,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(111,345,110.51)	92,829,291.24
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		1,830,366.31
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	1,830,366.31	94,659,657.55

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,339,752.50	338,395,772.83	683,558,673.61	1,213,294,198.94
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,339,752.50	338,395,772.83	683,558,673.61	1,213,294,198.94
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,339,752.50	338,395,772.83	683,558,673.61	1,213,294,198.94
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	191,339,752.50	338,395,772.83	683,558,673.61	1,213,294,198.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	95,917.66	95,917.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,339,752.50	338,395,772.83	683,654,591.27	1,213,390,116.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(95,917.66)	-	(95,917.66)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	109,799,236.30	109,799,236.30
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,339,752.50	338,299,855.17	793,453,827.57	1,323,093,435.24

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,673,084,000.00	1,255,244,782.40
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,673,084,000.00	1,255,244,782.40
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,599,016,000.00	1,189,765,072.40
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,020,303,100.00	828,151,820.04
210101	Үндсэн цалин	729,000,200.00	414,545,861.95
210102	Нэмэгдэл	180,086,600.00	322,456,429.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,674,800.00	16,602,000.00
210104	Урамшуулал	102,541,500.00	74,547,528.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	127,227,900.00	107,998,928.75
210201	Тэтгэврийн даатгал	85,721,200.00	73,136,672.77
210202	Тэтгэмжийн даатгал	10,376,600.00	8,610,907.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,188,400.00	4,591,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,188,400.00	4,541,617.96
210205	Эрүүл мэндийн даатгал	20,753,300.00	17,118,530.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,979,900.00	23,691,291.31
210301	Гэрэл, цахилгаан	9,334,900.00	7,514,576.31
210302	Түлш, халаалт	18,520,000.00	16,176,715.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	102,052,200.00	61,629,735.00
210401	Бичиг хэрэг	13,478,800.00	6,784,900.00
210402	Тээвэр, шатахуун	53,365,300.00	30,119,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,192,000.00	7,486,715.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,016,100.00	1,230,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,000,000.00	16,008,350.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	187,109,900.00	125,927,263.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	155,029,900.00	107,980,563.30
210502	Хоол, хүнс	18,680,000.00	13,047,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,400,000.00	4,899,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	73,687,600.00	23,560,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,087,600.00	7,000,000.00
210602	Тавилга	7,000,000.00	6,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	788,700.00
210604	Урсгал засвар	20,100,000.00	9,371,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,657,600.00	7,908,200.00
210702	Дотоод албан томилолт	9,657,600.00	7,908,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	33,383,900.00	6,422,024.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,983,900.00	4,381,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	208,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	243,884.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	88,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,613,900.00	4,475,610.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,613,900.00	4,475,610.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	74,068,000.00	65,479,710.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	74,068,000.00	65,479,710.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,434,000.00	23,845,710.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,634,000.00	41,634,000.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,673,053,500.00	1,348,074,073.64
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	29,979,900.00	24,686,791.31
132001	Орон нутгийн төсвөөс	29,979,900.00	24,686,791.31
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,570,587,200.00	1,256,274,462.33
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,570,587,200.00	1,256,274,462.33
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	72,486,400.00	67,112,820.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,656,100.00	67,112,820.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,830,366.31</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>94,659,657.55</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	2.00	1.00
610001	Төсвийн байгууллага	2.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,602.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд залруулагдах алдаа илрээгүй болно.

Аудитаар залруулагдаагүй 46,602.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 46,602.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 17,276.2 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

#### 3.2 Албан шаардлага

3.2.1 Эмийн зарцуулалтад аудитын горим хэрэгжүүлэхэд хэвтэн эмчлүүлэгчдийн сторын цагийн тарианы түүвэр болон эм баригчын эмийн түүврийн нэгтгэлийн зарлага 5735 ш, санхүүгийн программын эм боох материалын цагийн тариа 5485 ш буюу 250 ширхэг, эм боох материалыг анхан шатны баримтаас дутуу зарлага бүртгэсэн, тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.", ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээ болон гэрээний хавсралтыг зөрчсөн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Эм

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ

3.2.2. Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэнээс эм боох материалын үлдэгдэл өндөр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмийн захиалга хийдэггүйгээс он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл их, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, эм боох материалын зарлага бүртгэхдээ эхэлж авсанаа эхэлж зарлагдах аргыг хэрэглээгүй, эм боох материалын тооллого тооцоо хийж акт үйлдээгүйтэй холбоотой 41,685.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д "Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.", 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

### 3.3 Зөвлөмж

5.3.1 Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 4,917.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д ".Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 8.4-д ".Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй		4,917.60					1	4917,6
Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,	1	0.00			1	0.00		
Эм боох бараа материалын ангилалд буруу бүртгэсэн, эмийн үлдэгдэл их, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, эм боох материалын зарлага бүртгэхдээ эхэлж авсанаа эхэлж зарлагдах аргыг хэрэглээгүй, эм боох материалын тооллого тооцоо хийж акт үйлдээгүйтэй	1	41,685,3			1	41,685,3		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>46,602.9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>41,685,3</b>	<b>1</b>	<b>4,917,6</b>